

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны  
03 дугаар сарын 27-ны өдрийн Т/04  
тогтоолын 04 дүгээр хавсралт*

**ЧИНГИС ХААН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН  
ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ**

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмаар “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-д гишүүнээр элсэх компанид тавигдах шаардлага, нөхцөл, гишүүнээр элсүүлэх, хяналт тавих, гишүүнчлэлийн гэрээг цуцлах, Биржтэй хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Биржийн гишүүнээр элссэн зохицуулалттай этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос болон Биржээс баталсан дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү журамд орсон нэмэлт өөрчлөлтийг Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар”-ын дагуу төслийг боловсруулж, холбогдох этгээдээс санал авсны үндсэн дээр баталж, Хороогоор батламжлуулна.
- 1.4. Энэхүү журам болон журамд оруулсан нэмэлт өөрчлөлтийг Хороо батламжилсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд Биржээс өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 1.5. Энэхүү Журам болон журамд орох нэмэлт, өөрчлөлтийг Биржийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

## **ХОЁР. ГИШҮҮН ЭЛСҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 2.1. Бирж нь энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангасан этгээдийг гишүүнээр элсүүлнэ. Үүнд:
  - 2.1.1. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээд байх;
  - 2.1.2. Хорооноос үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан байх;
  - 2.1.3. Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг хангасан байх;
  - 2.1.4. Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх эрсдэлийн удирдлагын болон дотоод хяналтын дүрэм журамтай, эрсдэлийн сангийн хөрөнгийг тусгайлсан дансанд байршуулсан байх;

- 2.1.5. Компанийн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан, мэргэжилтнүүд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх;
- 2.1.6. Компанийн гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд, дотоод хяналтын ажилтан нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан байх;
- 2.1.7. Үнэт цаасны зохицуулалттай үйл ажиллагаанд үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамтай байх;
- 2.1.8. Биржийн гэрээт клирингийн байгууллагын гишүүнчлэлтэй байх;
- 2.1.9. Харилцагчид үйлчилгээ үзүүлэх программ хангамжтай, дээрх программ нь арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын программтай холбогдож мэдээлэл солилцох боломжтой, харилцагч өөрийн дансаар дамжуулан үнэт цаасны арилжаанд оролцох, удирдах боломжтой байх;
- 2.2. Биржийн гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэхүү журмын 2.1-д заасан шаардлагаас гадна Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар тогтоосон үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ тухайн чиглэлийн эрхийг авсан мэргэжилтэнтэй, үндсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дүрэм, журамтай байна.
- 2.3. Хорооноос мөнгөн хөрөнгийн номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй бол Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар тогтоосон өөрийн хөрөнгө, мэргэжилтэн, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байна.
- 2.4. Биржийн гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан үнэт цаасны дилерийн болон итгэмжлэгдсэн дилерийн үйл ажиллагаа эрхлэгч нь энэхүү журмын 2.1-д зааснаас гадна дилерийн үйл ажиллагаа явуулах дүрэм, журамтай, дилерийн үйл ажиллагаа эрхлэх орон тооны мэргэжилтэнтэй байна.
- 2.5. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь Биржийн гишүүнээр элсэхэд хөрөнгийн үнэлгээ, төсөл, судалгааны чиглэлээр ажиллах орон тооны мэргэжилтэнтэй, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх журамтай байна.

- 2.6. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь гишүүнээр элсэхэд энэхүү журмын 2.1-д зааснаас гадна хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг дагнан эрхлэх орон тооны мэргэжилтэнтэй, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний чиглэлээр байгуулах гэрээ, хэлцлийг боловсруулж, хянах орон тооны хуульчтай байна.

### **ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ЭЛСҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ**

- 3.1. Биржийн гишүүнээр элсэхээр хүсэлт гаргаж буй этгээд нь энэхүү журмын хавсралтад заасан өргөдлийн маягт (маягт 1)-ыг бөглөн, доорх бичиг баримтыг хавсаргаж ирүүлнэ. Үүнд:
- 3.1.1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм;
  - 3.1.2. Хорооноос олгосон үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тогтоол, гэрчилгээний хуулбар;
  - 3.1.3. Хороонд бүртгэлтэй аудитын компаниар баталгаажуулсан сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан;
  - 3.1.4. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан мэргэжилтний эрхийн үнэмлэхийн хуулбар;
  - 3.1.5. Компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр баталсан үндсэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дүрэм, журмын хуулбар;
  - 3.1.6. Хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирлын анкет, тохиромжтой этгээдийг тодорхойлохтой холбоотой төрийн эрх бүхий байгууллагуудын лавлагаа;
  - 3.1.7. Мөнгөн хөрөнгийн номинал дансны болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй бол зөвшөөрөл олгосон Хорооны тогтоолын хуулбар;
  - 3.1.8. Санхүүгийн бичиг баримтад гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар.
- 3.2. Бирж нь гишүүнээр элсэх өргөдөл гаргагчийн хүсэлтийг хуанлийн 10 хоногт багтаан хянана.
- 3.3. Гишүүнээр элсэх өргөдөл гаргагчийн бичиг баримтыг бүрдэл дутуу бол Бирж энэ талаар өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ журмын 3.2-д заасан хугацааг бичиг баримтын бүрдэл бүрэн болсон өдрөөс эхлэн тооцно.

- 3.4. Биржийн гишүүнчлэлд шинэ гишүүн элсүүлэх материалыг Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж хянаж, шаардлага хангасан гэж үзвэл Гүйцэтгэх удирдлагад танилцуулан Гүйцэтгэх захирлын тушаалаар тухайн хүсэлт гаргагчийг Биржийн гишүүнээр элсүүлэх шийдвэр гаргана.
- 3.5. Гишүүнээр элсүүлэх шийдвэр гарсан тохиолдолд Биржийн гүйцэтгэх захирал өргөдөл гаргасан этгээдтэй ажлын хоёр хоногт багтаан гишүүнчлэлийн гэрээ (хавсралт 1) байгуулна.
- 3.6. Бирж нь дараах үндэслэлээр өргөдөл гаргагч этгээдийг гишүүнээр элсүүлэхээс татгалзана.
- 3.6.1. Гишүүнээр элсэхэд шаардлагатай бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон;
- 3.6.2. Хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд гүйцэтгэх захирал мэргэжилтнүүд нь санхүүгийн гэмт хэрэгт шалгагдаж байгаа эсхүл сүүлийн 5 жилийн хугацаанд санхүүгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон;
- 3.6.3. Энэхүү 3.1-д заасан бичиг баримтын бүрдэл, агуулгын шаардлагыг хангаагүй;
- 3.6.4. Хүсэлт гаргасан этгээд Биржийн гишүүнээр элсэж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нь түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компанийн хувьд хуулиар хориглогдсон үйл ажиллагаа гэж үзсэн.
- 3.7. Бирж хүсэлт гаргагчийг гишүүнээр элсүүлэхээс татгалзах шийдвэр гаргасан бол энэ тухай албан бичгээр хүсэлт гаргагчид мэдэгдэж, шийдвэрийн хуулбарыг хүргүүлнэ.
- 3.8. Бирж хүсэлт гаргагчийг гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд хүсэлт гаргагч 6 сарын хугацаанд дахин өргөдөл гаргах эрхгүй.
- 3.9. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Хавсралт 1-д заасан Гишүүнчлэлийн гэрээний үлгэрчилсэн загварыг өөрчилж болно.

#### **ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖ, ХӨНГӨЛӨЛТ ЧӨЛӨӨЛӨЛТ**

- 4.1. Бирж нь өөрийн гишүүн байгууллагуудаас элсэлтийн болон жилийн хураамжийг авах бөгөөд гишүүн нь энэхүү журмаар тогтоосон хэмжээгээр элсэлтийн болон жилийн хураамж төлөх үүрэг хүлээнэ.

- 4.2. Шинээр гишүүнээр элсэж буй этгээдийн элсэлтийн хураамж 20,000,000 (хорин сая) төгрөг байх бөгөөд гишүүн нь элсэлтийн хураамжийг гишүүнээр элсүүлэх шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт багтаан Биржийн дансанд төвлөрүүлнэ.
- 4.3. Хорооны тусгай зөвшөөрөлтэй бусад биржийн гишүүн Биржид гишүүнээр элссэн тохиолдолд хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх бөгөөд энэ тохиолдолд хөнгөлөлт чөлөөлөлтийн хугацаа, хэмжээг Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
- 4.4. Гишүүний жилийн хураамж 1,000,000 (нэг сая) төгрөг байх бөгөөд гишүүн нь жилийн хураамжийг тухайн жилийн эхний сард багтаан, эсхүл улирал тутам 4 хуваан дараа сарын 10-ны өдрийн дотор төлнө.
- 4.5. Шинээр элссэн гишүүнийг гишүүнээр элссэнээс хойш нэг жилийн хугацаанд жилийн хураамжаас чөлөөлнө.

#### **ТАВ. ГИШҮҮНИЙ ЭРХИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ**

- 5.1. Гишүүний эрхийг сайн дурын буюу өөрийн хүсэлтээр эсвэл Биржээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гишүүнчлэлийн гэрээг цуцалж, гишүүний эрхийг дуусгавар болгоно.
- 5.2. Энэ журмын 5.1–д зааснаар гишүүн өөрийн хүсэлтээр гишүүнчлэлийн гэрээг цуцлах тохиолдолд тухайн хүсэлтийг албан бичгээр гаргах бөгөөд Гүйцэтгэх захирал гишүүнчлэлийн гэрээг цуцална.
- 5.3. Гишүүн өөрийн хүсэлтээр гишүүнчлэлийн гэрээг цуцлах хүсэлт ирүүлсэн нь гишүүний төлөгдөөгүй жилийн хураамжийн үлдэгдлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 5.4. Гишүүний үйл ажиллагаанд дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Биржээс гишүүнтэй байгуулсан гэрээг цуцалж, гишүүний эрхийг дуусгавар болгоно.
  - 5.4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооноос баталсан дүрэм, журам, Биржээс баталсан дүрэм, журам, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлаас баталсан шийдвэрийг удаа дараа (нэг улирлын дотор 3 болон түүнээс дээш эсвэл дараалан 3 болон түүнээс дээш удаа) биелүүлээгүй;
  - 5.4.2. Олон нийтийг төөрөгдүүлэх худал ташаа мэдээлэл санаатайгаар тараасан, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал үүссэн;
  - 5.4.3. Биржээс дүрэм журмын дагуу тавигдсан шаардлагуудыг удаа дараа (нэг улирлын дотор 3 болон түүнээс дээш удаа) биелүүлээгүй;
  - 5.4.4. Хорооноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

- 5.4.5. Гишүүнчлэлийн гэрээний хугацаа дуусгавар болсон;
- 5.5. Гишүүнчлэлийн гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Биржийн гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийн дагуу гишүүнчлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, гүйцэтгэх захирлаас өгсөн чиглэлийн дагуу гишүүний арилжааны эрхийг нэн даруй зогсоож, зохих арга хэмжээг авна.

### **ЗУРГАА. ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ**

- 6.1. Биржийн гишүүн нь дараах нийтлэг үүргийг биелүүлж ажиллана. Үүнд:
- 6.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хороо, Биржээс баталсан дүрэм, журмыг мөрдөж ажиллах;
- 6.1.2. Үнэт цаасны арилжааг шударгаар явуулж, хууль зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;
- 6.1.3. Энэхүү журмаар тогтоосон гишүүнчлэлийн шаардлага нөхцөлийг байнга биелүүлж ажиллах;
- 6.1.4. Гишүүн нь өөрийн санхүүгийн тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд Биржид хүргүүлэх, хувь нийлүүлсэн хөрөнгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах;
- 6.1.5. Гишүүнчлэлийн жилийн хураамжийг тогтоосон хугацаанд Биржийн дансанд төвлөрүүлэх;
- 6.1.6. Биржийн журмаар тогтоосон тухай бүр ирүүлэх мэдээлэл болох хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг шинээр томилох, оноосон нэр өөрчлөх, салбар төлөөлөгчийн газар шинээр байгуулах, нэмэлт тусгай зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг тухай бүр ирүүлэх;
- 6.1.7. Биржээс олгосон кодыг бусдад шилжүүлэхгүй, ашиглуулахгүй, дамжуулахгүй байх;

### **ДОЛОО. ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

- 7.1. Биржийн гишүүн хариуцсан мэргэжилтэн нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллах бөгөөд Хороо болон мэргэжлийн холбоотой хамтран хяналт шалгалтыг хэрэгжүүлж болно.
- 7.2. Биржийн гишүүн хариуцсан мэргэжилтэн гишүүний талаар түүнээс ирүүлсэн болон өөрийн цуглуулсан мэдээлэл, харилцагч хөрөнгө оруулагчдаас гаргасан гомдол, саналд тулгуурлан дүн шинжилгээ хийх замаар хяналтыг хэрэгжүүлнэ.

- 7.3. Биржийн гишүүн хариуцсан мэргэжилтэн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Биржээс гишүүнд сануулах арга хэмжээг авч, гаргасан зөрчлөө засах хугацаат үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлнэ.
- 7.4. Гишүүн нь гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн жилийн хураамж төлөх үүргээ биелүүлээгүй, Хороо болон Биржээс баталсан дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн (нэг улирлын дотор 3 болон түүнээс дээш удаа), зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл гаргасан тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг Биржээс 1 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.
- 7.5. Гишүүн нь арилжаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй, зөрчлийг арилгахаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, сүүлийн 1 жилийн хугацаанд арилжаанд оролцоогүй, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл хүчингүй болох нөхцөл бүрдсэн тохиолдолд Бирж гишүүний эрхийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлж, энэ талаар Хороонд мэдэгдэнэ.
- 7.6. Энэхүү журмын 5 дугаар бүлэгт заасан нөхцөл байдал үүссэн гэж үзвэл Бирж гишүүнчлэлийн гэрээг цуцалж гишүүний эрхийг дуусгавар болгоно.
- 7.7. Энэхүү журмын 7.6-д заасан арга хэмжээг Биржээс гаргасан тохиолдолд ажлын 3 хоногийн дотор Хороо, бусад мэргэжлийн байгууллага, олон нийтэд мэдэгдэнэ.

---oOo---

Батлав

“Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

.....

Батлав

“.....” .....-ийн  
Гүйцэтгэх захирал

.....

## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

202.... оны ..... дугаар  
сарын ..... -ны өдөр

Дугаар ....

Улаанбаатар хот

Нэг талаас “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлөн ....., нөгөө талаас Биржийн гишүүн үнэт цаасны компанийг төлөөлж “.....” (цаашид “Гишүүн”, хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г гурван жилийн хугацаатай байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь үнэт цаасны компанийг гишүүнээр элсүүлж, үнэт цаасны арилжаанд оролцох, Гишүүн нь харилцан тохиролцсон гишүүнчлэлийн төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Талууд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржээс баталсан журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.
- 1.3. Гишүүн байгууллага нь Гэрээг байгуулснаар арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан, үнэт цаасны компанийн үйл ажиллагаа явуулах хуулийн болон хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн чадамжтай гэх баталгаа гаргаж байгаа бөгөөд уг баталгааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг бие даан хариуцна.
- 1.4. Гишүүн байгууллага нь холбогдох хууль, тогтоомж болон Гэрээнд заасан баталгааг хангаж чадахгүй болсон тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.

## **Хоёр. Талуудын эрх, үүрэг**

### **2.1. Бирж нь дараах эрх эдэлнэ:**

- 2.1.1. “Гишүүнчлэлийн журам” болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээний хураамж болон холбогдох бусад төлбөрийг Гишүүнээр цаг тухайд нь төлүүлэх, тогтоосон хугацаанд төлөөгүй нөхцөлд “Гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу хариуцлага ногдуулах;
- 2.1.2. Гишүүний хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Биржээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
- 2.1.3. Гишүүний санхүүгийн тайлан мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
- 2.1.4. Гишүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, өргөдөл гомдлын дагуу болон журам заавар, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, Биржийн баталсан “Дотоод хяналтын журам”, болон бусад холбогдох журам, гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулах, тус саналыг Хороонд хүргүүлэх;
- 2.1.5. Гишүүний гаргасан зөрчил нь хөрөнгө оруулагч, харилцагчдад хохирол учруулсан бөгөөд хохирлоо барагдуулаагүй, мөн гэмт хэргийн шинжтэй бол холбогдох материалыг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

### **2.2. Биржийн хүлээх үүрэг:**

- 2.2.1. Өдөр тутмын арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн холбогдох журмын дагуу зохион байгуулах, арилжааны программын хэвийн ажиллагааг хангах;
- 2.2.2. Гишүүний гаргасан хүсэлтийн дагуу техник хангамж, программ хангамжийг Биржийн сүлжээнд анх холбоход шаардлагатай техникийн болон үйл ажиллагааны туслалцааг үнэ төлбөргүйгээр үзүүлэх, арилжааны системийг ашиглах заавар, зөвлөгөө өгөх;
- 2.2.3. Харилцагч болон гишүүнээс ирүүлсэн санал, хүсэлтэд холбогдох алба, нэгж нь утсаар болон бусад арга, хэрэгслээр хариу өгөх;
- 2.2.4. Гишүүнийг арилжаанд оролцох, мэдээлэл авах ижил нөхцөлөөр хангах;

- 2.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах бөгөөд хөрөнгө, санхүү, ашиг, техниктэй холбоотой баримт бичиг, мэдээлэл нь нууцлалд хамаарагдана.
- 2.3. Гишүүн нь дараах эрх эдэлнэ:
- 2.3.1. Үнэт цаасны арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүй гаргуулан авах;
- 2.3.2. Үнэт цаасны зах зээл, Бирж, Гишүүний үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргах, Биржтэй хамтран ажиллах;
- 2.3.3. Биржийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах;
- 2.3.4. Биржид санал хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх;
- 2.3.5. Биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд Хороонд гомдол гаргах;
- 2.4. Гишүүн нь дараах үүрэг хүлээнэ:
- 2.4.1. Арилжааны системд Биржийн "Гишүүнчлэлийн журам"-д заасан шаардлага хангасан техник хэрэгсэл ашиглах ба Арилжааны системд нэвтрэх код, программ хангамжийн тохиргоо, түүний нууцлал, хамгаалалтыг хангаж, зориулалтын дагуу ашиглах, үүнтэй холбоотойгоор гарах аливаа зардлыг хариуцах;
- 2.4.2. Гишүүний үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь Биржийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх авсан байх;
- 2.4.3. "Гишүүнчлэлийн журам"-д заасны дагуу дараах үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлнө. Үүнд:
- 2.4.3.1. Гишүүний жилийн хураамжийг тухайн жилийн эхний сард багтаан, эсхүл улирал тутам 4 хуваан дараа сарын 10-ны өдрийн дотор;
- 2.4.3.2. Торгууль, алдангийг тогтоосон хугацаанд багтаан төлөх;
- 2.4.4. Гишүүний ажлын байрны байршил, хаяг тодорхой байх, олон нийтэд тодорхой бус нөхцөлд ойролцоо гарц гармын дагуу тэмдэг тавих, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, харилцагчдыг хүлээн авах цагийн хуваарь гарган тогтмол мөрдөж ажиллах;

- 2.4.5. Тухайн жилийн арилжааны төлөвлөгөөг 1 дүгээр сарын 25-ны дотор Биржид ирүүлж, биелэлтийг хангаж ажиллах;
- 2.4.6. Биржид дараах мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлнэ:
- 2.4.6.1. Жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бэлтгэж, жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт дараа оны 3 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор Биржид тус тус ирүүлэх;
- 2.4.6.2. Компанийн дүрэм, журамд орсон өөрчлөлтийг ажлын 10 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;
- 2.4.6.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчний талаарх мэдээлэл түүнд орсон өөрчлөлтийг ажлын 8 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;
- 2.4.6.4. Компанийн хаяг, байршил түүнд орсон өөрчлөлтийг ажлын 5 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;
- 2.4.6.5. Харилцагчдаас авах арилжааны шимтгэлийн хувь хэмжээ (бүтээгдэхүүн тус бүрээр);
- 2.4.7. Холбогдох журмын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, түүний үнэн зөвийг хариуцах, харилцагчийн утсаар өгсөн захиалгыг дуу хоолойны болон дүрст бичлэгээр баталгаажуулж, бичлэгийг компьютерын санамжид файл хэлбэрээр хадгалах, цахим хэлбэрээр ирүүлсэн захиалгыг захиалгын гэрээнд хавсаргах, цахим хэлбэрээр захиалга авах тусгай программ хэрэглэх, хяналт шалгалтын ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд анхан шатны баримт, холбогдох бусад баримт мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;
- 2.4.8. Гишүүн нь өөрийн цахим хуудастай байж харилцагчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллах;

### **Гурав. Харилцаа холбоо**

- 3.1. Бирж нь Гишүүнд мэдээллийг Биржийн цахим хуудас эсвэл цахим шуудангаар болон албан бичгээр хүргүүлж болно.
- 3.2. Гишүүн нь Биржид хүргүүлэх аливаа мэдээллийг бичгээр хүргүүлнэ.
- 3.3. Энэхүү гэрээний 3.1-д заасны дагуу Биржээс мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн тохиолдолд ажлын 5 өдөрт, цахим шуудангаар илгээсэн болон цахим хуудаст нийтэлсэн тохиолдолд тухайн өдөр гишүүнийг танилцсанд тооцно.

### **Дөрөв. Талуудын хариуцлага**

- 4.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцан барагдуулна.
- 4.2. Гишүүн нь гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд Бирж гишүүнд дараах арга хэмжээг авч, үүргийн биелэлтийг хангуулна. Үүнд:
  - 4.2.1. Зөрчлийг арилгах тухай хугацаатай үүрэг даалгавар албан бичгээр өгч, сануулах;
  - 4.2.2. Зөрчлийн талаар Хороонд албан бичгээр мэдэгдэж, энэ тухай гишүүнд сануулах;
  - 4.2.3. Зөрчлийн талаар мэргэжлийн байгууллагад албан бичгээр мэдэгдэж, энэ тухай гишүүнд сануулах;
  - 4.2.4. Гэрээний 2.4.3.1-т заасан гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд Иргэний хуулийн 232.6-д заасныг үндэслэн хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар тооцож алданги төлүүлэх;
  - 4.2.5. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлан, энэ тухай Хороонд албан бичгээр мэдэгдэх;
  - 4.2.6. Гишүүний арилжаанд оролцох эрхийг хугацаатай түдгэлзүүлэн, энэ тухай Хороо, мэргэжлийн байгууллага, олон нийтэд мэдээлэх;
  - 4.2.7. Гишүүнчлэлийн гэрээг цуцлан, энэ тухай Хороо, мэргэжлийн байгууллага, олон нийтэд мэдээлэх;
- 4.3. Гишүүн нь ногдуулсан торгуулийг ажлын 10 өдөрт багтаан төлөөгүй тохиолдолд түүнд гэрээний 4.2.4, 4.2.5-т заасан хариуцлагыг хүлээлгэж болно.
- 4.4. Гишүүн нь гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээний 4.2-т заасан хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран буруутай этгээдийн гишүүний эрхийг

үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, гишүүнчлэлийн гэрээг цуцлах арга хэмжээ авч болно.

#### **Тав. Бусад зүйл**

- 5.1. Цахилгаан, сүлжээний дэд бүтэц (үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хамаарах) болон Биржийн үйл ажиллагаанаас үл хамаарах бусад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөлийн улмаас үүссэн аливаа хохирлыг Бирж хариуцахгүй.
- 5.2. Энэхүү гэрээг хугацааны эцэст дүгнэж, цаашид сунгах асуудлыг шийдвэрлэнэ. Аль нэг талаас гэрээг дуусгавар болгох санал гаргаагүй бол мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 5.3. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба 30 хоногийн дотор тодорхой шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

“Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал .....

.....

“.....” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал .....

.....

## Гишүүнчлэлийн хураамж

| Ангилал                    | Хураамжийн хувь хэмжээ<br>(төгрөгөөр) | Давтамж  |
|----------------------------|---------------------------------------|----------|
| Гишүүний элсэлтийн хураамж | 20,000,000.00                         | Нэг удаа |
| Гишүүний жилийн хураамж    | 1,000,000.00                          | Жил бүр  |

**“Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК-ийн гишүүнээр элсэх  
хүсэлт гаргах өргөдлийн маягт**

|                                                                                                 |                                             |                       |
|-------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|-----------------------|
| <b>Үзүүлэлт</b>                                                                                 |                                             |                       |
| Зохицуулалттай этгээдийн нэр:                                                                   |                                             |                       |
| Байгуулагдсан он:                                                                               |                                             |                       |
| Улсын бүртгэлийн дугаар<br>болон регистрийн дугаар:                                             |                                             |                       |
| Хаяг                                                                                            |                                             |                       |
| Компанийн холбоо барих утас                                                                     |                                             |                       |
| Цахим хуудас/цахим шуудан                                                                       |                                             |                       |
| Тусгай зөвшөөрлийн төрөл,<br>Хорооны тогтоолын дугаар                                           | <b>Брокер</b>                               |                       |
|                                                                                                 | <b>Дилер</b>                                |                       |
|                                                                                                 | <b>Андеррайтер</b>                          |                       |
|                                                                                                 | <b>Хөрөнгө оруулалтын<br/>зөвлөх</b>        |                       |
| Биржид элсэхийг хүсэж буй<br>гишүүдийн төрөл                                                    | <b>Брокер</b>                               |                       |
|                                                                                                 | <b>Дилер</b>                                |                       |
|                                                                                                 | <b>Хөрөнгө оруулалтын<br/>зөвлөх</b>        |                       |
|                                                                                                 | <b>Андеррайтер</b>                          |                       |
| Хувьцаа эзэмшигчдийн нэрс                                                                       | <b>Эзэмшиж буй хувьцааны<br/>тоо ширхэг</b> | <b>Үнийн дүн</b>      |
|                                                                                                 |                                             |                       |
|                                                                                                 |                                             |                       |
|                                                                                                 |                                             |                       |
|                                                                                                 |                                             |                       |
| Зохицуулалттай этгээдийн<br>салбар, төлөөлөгчийн газрын<br>мэдээлэл                             | <b>Хаяг</b>                                 | <b>Байршил</b>        |
| Гүйцэтгэх захирлын мэдээлэл<br>(ҮЦЗЗ-д ажиллах эрхийн<br>үнэмлэхийн дугаарыг оруулж<br>бөглөнө) | <b>Боловсрол</b>                            | <b>Ажлын туршлага</b> |
|                                                                                                 |                                             |                       |
|                                                                                                 |                                             |                       |
| Тухайн тусгай зөвшөөрөлтэй<br>үйл ажиллагааг хариуцан<br>ажиллах мэргэжилтнүүдийн<br>мэдээлэл   | <b>Боловсрол</b>                            | <b>Ажлын туршлага</b> |
|                                                                                                 |                                             |                       |

### Гарын үсгийн баталгаа

Огноо:

Хэнд: Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг,  
18 дугаар хороо,  
Богд Жавзандамба гудамж  
Эл Эс Плазагийн 2 давхар  
"Чингис хаан хөрөнгийн бирж" ХХК

| Гишүүний нэр                  |                   | Дансны дугаар          |                      |
|-------------------------------|-------------------|------------------------|----------------------|
|                               |                   |                        |                      |
| Овог, нэр                     | Регистрийн дугаар | Албан тушаал           | Баталгаат гарын үсэг |
| 1-р гарын үсэг                |                   |                        |                      |
|                               |                   |                        |                      |
| 2-р гарын үсэг                |                   |                        |                      |
|                               |                   |                        |                      |
| Гишүүний тамга, тэмдэг дардас |                   | Нотариатын тэмдэглэгээ |                      |
|                               |                   |                        |                      |